

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээ	Хугацаа	Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төгрөг):*	Суурь түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)	Хэрэгжилт хангалтгүй бол шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй бичих
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
26	510. Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд	2025 - 2026			-	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/145 дугаар тушаалаар Газрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгааг гүйцэтгэж, үзэл баримтлалын төслийг боловсруулж байна.	30%	
28	511. Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025 - 2026			-	Кадастрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, мөн хуулийн төслийг үзэл баримтлалын төсөлд нийцүүлэн боловсруулах үүрэгтэй Ажлын хэсгийг тус газрын даргын оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар байгуулсан.	30%	

29	512. Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025 - 2026			-	Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2025 оны 04 сарын 03-ны өдөр батлуулж, Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 1/1896 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100 %	
30	513. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2025 - 2026			-	1.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/190 дүгээр албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/148 дугаар тушаалаар Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. 2.Хуулийн төслийг олон нийтэд байгууллагын цахим хуудаст 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байршуулан санал авсан. Мөн хуулийн төслийг олон нийтэд хэлэлцүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагууд, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын гишүүд, инженерүүдийн дунд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан.	70%	
31	514. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг	2025 - 2026		-	30	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр	100 %	Орон зайн өгөглийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал батлагдахгүй байгаас шалтгаалж байна.

	боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх					1/1630 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Үзэл баримтлалын төслийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр дахин ЗГХЭГ-т хүргүүлэв.		
48	977. Газрын мониторингийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх	2025-2028	Улсын төсөв	159.3 сая төгрөг	3000	Газрын мониторингийн сүлжээний мониторингийн 500 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны АД/2025-06 дугаартайгаар батлуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2025.02.14-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулсан. Гүйцэтгэгчийг холбогдох хууль эрх зүйн хүрээнд тус ажлыг 2 багцад хуваан гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Багц 1 буюу Баян-Өлгий, Ховд аймгуудын мониторингийн 200 цэгт хянан баталгааны ажлыг гүйцэтгэхээр “Геоботаник” ХХК шалгарч 2025.05.30-ны өдрийн 2025/89 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгчээс 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 73/25 дугаар албан бичгээр Бэлтгэл үе шатны тайланг ирүүлсэнд захиалагчийн хяналт хийж, холбогдох засвар сайжруулалтыг хийлгүүлсэн. Багц 2-т буюу Завхан, Увс аймгуудийн мониторингийн 300 цэгт хянан баталгааны ажлыг	30%	

						гүйцэтгэхээр “Газар дэлхий” ХХК шалгарч 2025/62 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгчтэй 2025.05.08-ны өдөр ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх уулзалтыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээс 2025.05.20-ны өдрийн 02/79 дүгээр албан бичгээр бэлтгэл үе шатны тайлан ирүүлсэнд захиалагчийн хяналтыг гүйцэтгэж дүгнэлт үйлдэн №2025/ГЗБ/07 дугаартай актаар хүлээж авсан.		
50	978. Маш хүчтэй доройтсон газрын ашиглалтыг нэгдмэл сангийн ангиллаар тодорхойлох, нөхөн сэргээх	2025 - 2028	Орон нутгийн төсөв		3.9	Улсын хэмжээд аймгуудын хэмжээнд 2024 онд Газарт учруулсан хохирлын дүнгээр 3,453,181 га газарт хохирол учирсан байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тусгуулж газар хамгаалах нөхөн сэргээх шаардлагатай байршлын судалгааг гарган Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус ГЗБГЗЗЕГ-ын даргын 1/2043 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. 2025 онд улсын хэмжээнд 2,655,581 га газарт газар хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр арга хэмжээг төлөвлөсөн байна.	30%	
56	1060. Төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг үнэлэхэд төрийн бус байгууллага,	2025 - 2028			0	2025 оныг иргэдэд нээлттэй, ил тод төрийн үйлчилгээний жил болгон зарлаж, салбарын хэмжээнд арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг батлан харьяа газруудад хүргүүлэн, хэрэгжилтийг улирал	100 %	

	иргэдийн оролцоог хангах арга хэмжээ хэрэгжүүлэх					тутам хянаж, тайлагнаж ажиллаж байна. Газрын харилцааны салбарын хувьд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийг хангах чиглэлээр харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, хуулийн шаардлагыг зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Энэхүү хяналт, үнэлгээ нь салбарын мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэдийн итгэл, хүлээлтэд нийцсэн төрийн үйлчилгээг хангахад чиглэгдсэн байна. Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, үнэт цаас, байгууллагатай холбоотой мэдээлэл байршуулах албан хаагч нарыг газрын даргын 2025 оны “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” А/221 тушаалаар томилон хуулийн хугацаанд байршуулан, ил тод мэдээллэж байна. Мөн харьяа 22 байгууллагын мэдээ, тайланг хуулийн хугацаанд, бүрэн зөв мэдээлсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1 төсөл,	
--	--	--	--	--	--	--	--

						арга хэмжээний мэдээллийг https://www.publicinvestment.gov.mn/ цахим хуудсанд байршуулан олон нийтэд ил тод хүргэсэн.		
57	1062. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх системийг хөгжүүлэн нээлттэй мэдээллийг тогтмол нийтлэх	2025			-	Салбарын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор www.egazar.gov.mn цахим системийг хөгжүүлэн, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын мэдээллийг бодит хугацаанд олон нийтэд ил тод хүргэж байна. Иргэдэд газрын эрхийн гэрчилгээ, кадастрын мэдээллийг QR код, нэвтрэлтийн системээр шууд үзэх боломжийг бүрдүүлж, газрын зураглал, хил хязгаар, зориулалтын давхаргуудыг ойлгомжтой байршуулж байна. Цахим системийн хэрэглээний гарын авлага, зааварчилгааг цахимаар байршуулж, хэрэглэгчдийн систем ашиглах чадварыг сайжрууллаа. Мэдээллийн шинэчлэлтийн давамжийг тогтмол хянан, аймаг, нийслэлийн газар, хэлтсүүдийн цахим хуудстай уялдуулан мэдээллийг нэг сувгаар түгээх зохион байгуулалтыг амжилттай хэрэгжүүлж байна. Иймд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангах арга хэмжээ төлөвлөгдсөн ёсоор хэрэгжиж байна.		
61	1087. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний	2025 - 2027				Шударга байдлын үнэлгээний судалгааг АТГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/129 тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын		

	төлөвлөгөөг эрчимжүүлэх				дагуу хийж гүйцэтгэжээ. Шударга байдлын үнэлгээ нь гадаад шударга байдал, дотоод шударга байдал болон бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг байна. Гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагаар үйлчлүүлэн үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын өгч буй үнэлгээгээр тодорхойлогддог бөгөөд “Шударга байдлын үнэлгээ-2024” судалгаанд төрийн 81 байгууллагаар үйлчлүүлсэн 10840 иргэд, ААН-ийн төлөөлөл, 2660 төрийн албан хаагчдын төлөөлөл, 1530 бодлогод, оролцогч, шинжээчид хамрагдсан байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын хувьд 2022, 2023 онд 33 агентлагийн үйл ажиллагаанд шударга байдлын үнэлгээгээр 10 дугаар байранд үнэлэгдэж байсан бол 2024 оны Шударга байдлын үнэлгээгээр 34 агентлагаас 6 дугаар байранд үнэлэгдсэн байна. Мөн төрийн 81 байгууллагаас 7 дугаар байранд үнэлэгдсэн байна. ГЗБГЗЗЕГ-аас 2025 онд шударга байдлын үнэлгээний гадаад болон дотоод шударга байдал, бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулахад анхаарч, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод		
--	----------------------------	--	--	--	--	--	--

						байдлыг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025.01.29-ний өдрийн А/26 дугаар тушаалаар Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан бөгөөд уг нь төлөвлөөгөөнд тусгагдсан арга хэмжээг салбарын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.		
65	1113. Байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн байрлалын тулгуур сүлжээг байгуулах	2025 - 2028			48	1.Улсын хилийн дагуу GNSS-ийн Байнгын ажиллагаатай суурин станц суурилуулах, GNSS-ийн хэмжилтийн RTX төхөөрөмж худалдан авах техникийн тодорхойлолтыг боловсруулж 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр батлуулсан. 2025 оны 06 дугаар сарын 24-ний 2025/ГЗЗХ-04, 2025/ГЗЗХ-05 дугаар актаар хүлээж авсан. 2.2025 онд улсын хил шалгалтын ажлын төсвөөр GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 суурин станц байгуулах ажлын төсвийг түдгэлзүүлсэн тул Улсын төсвийн хөрөнгөөр станц байгуулахаар ЗГХЭГ-т зөвшөөрөл авах албан бичгийг хүргүүлсэн. 3.Байнгын ажиллагаатай суурин станцуудаас бүрдсэн геодезийн байрлалын тулгуур сүлжээний нарийвчлалыг сайжруулах зорилгоор 2026 онд шинээр байгуулах 10 станцын төсвийн	30%	

						тооцоо болон холбогдох мэдээллийг гаргаж 2026 оны төсөвт тусгахаар Сангийн Яаманд хүргүүлсэн.		
66	1114. Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг олон улсын түвшин, стандартад нийцүүлэн шинэчлэх	2025 - 2028			2	Төрөл бүрийн геодезийн хэмжилт, зураглал гүйцэтгэхэд ашигладаг хэмжих хэрэгслийг шалгаж, тохируулах болон хяналтын хэмжилтэд зориулан 1км нүүлтийн дундаж квадрат алдаа 0.2мм-ийн нарийвчлалтай Sokkia фирмийн SDL1X маркийн тоон нивелир, BIS30A маркийн бар кодтой инвар рейк 2ш, бусад дагалдах хэрэгслийн хамт худалдан авч лабораторийн эталон багажийг шинэчилсэн. Мөн лабораторийн шалгалт баталгаажуулалтын ачаалал бууруулах, цаг хугацааг хэмнэх зорилгоор олон улсын стандартад нийцүүлэн дунд болон техникийн нарийвчлалтай хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах полигоныг шинээр байгуулах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн зарлалыг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд зарласан. Тендерийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нээж дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах сорилт, туршилт явуулах “Жишилтийн полигон” байгуулах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.	50%	

67	1115. Монгол орны нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулж батлан хамгаалах, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын үйл ажиллагаанд ашиглуулах	2025 - 2028 он			704000	1:25000-ны масштабтай байр зүйн зургийг хийх ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоо гаргаж 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн н/21 дугаартай албан бичгээр ҮАБЗ-д хүргүүлсэн. Геодези, зураг зүйн чиглэлээр хийх ажлын \1:25000-ны масштабтай байр зүйн зураглал, 1:1000-ны масштабтай байр зүйн зураглал, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, Өндрийн сүлжээ байгуулах, Геодези, зураг зүйн дэд систем, Багаж баталгаажуулалтын төхөөрөмж үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоог гаргаж, 2026 оны төсөвт тусгуулахаар 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	30%	
68	1116. Газар зүйн нэрийн тодруулалт хийж мэдээллийн сан бүрдүүлэх, иргэд, байгууллагыг үнэн зөв газар зүйн нэрийн лавлагаа мэдээллээр хангах	2025 - 2028			117 сум, 5 дүүрэг	1.2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр 7 аймгийн 23 сум, нийслэлийн 2 дүүрэг уг ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр төсвөө баталж, 6 аймгийн 22 сум, нийслэлийн 2 дүүргийн Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаварт санал өгч, хамтран ажилласан. 2.Газар зүйн нэрийн зөвлөл (ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/241 дүгээр тушаал)-ийн хурлыг 2025.04.01, 2025.06.20-ны өдөр тус тус 2 удаа зохион байгуулсан бөгөөд Дундговь аймгийн Баянжаргалан сум, Говь-Алтай аймгийн Цээл сум, Төв аймгийн Баян, Батсүмбэр, Баянчандмань, Мөнгөнморьт сум, Өвөрхангай	50%	

					аймгийн Уянга сум, Нийслэлийн Баганхангай, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын үр дүнг танилцуулсан. 3.Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн оноосон 319 нэрийг өөрчлөх, 47 уламжлалт газар зүйн нэрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр аймгийн ИТХ-ын даргад 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1/819, аймгийн Засаг даргад 1/821 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 2-01/542 дугаар албан бичгээр Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах өөрчлөх батлуулах, шинээр батлуулах газар зүйн нэрийг Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцэж 52 дугаар тогтоолоор гаргасан шийдвэрийг ирүүлсэн. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн оноосон 319 нэрийг өөрчлөх, 47 уламжлалт газар зүйн нэрийг УИХ-аар батлуулах тогтоолын төсөл болон хавсралтыг бэлтгэж 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1419 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах УИХ-аар өөрчлөн батлуулах, шинээр батлуулах газар зүйн нэрийн жагсаалтын хавсралтыг засварлан 2025 оны 05		
--	--	--	--	--	---	--	--

						дугаар сарын 21-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. УИХ-аар өөрчлөн батлуулах, шинээр батлуулах газар зүйн нэрийн жагсаалтын хавсралтыг засварлан 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр ЗГХЭГ-ын референтэд цахим шуудангаар хүргүүлсэн. 4.Дундговь аймгийн Дэлгэрхангай, Сайхан-Овоо сум, Увс аймгийн Тэс сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хамаарах зарим уул, нуруу, булаг зэргийн газар зүйн нэрийн лавлагааг 3 иргэний хүсэлтийн дагуу гаргаж өгсөн. 5.2021-2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган аймгийн Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын үр дүнд бий болсон УИХ-аар өөрчлөн батлуулах, шинээр батлуулах газар зүйн нэрийг аймгийн ИТХ-ын 2024 оны III/20 тогтоолоор УИХ-аар батлуулахыг дэмжсэн шийдвэрийг үндэслэн Булган аймгийн нутаг дэвсгэрт хамаарах өөрчлөн батлуулах, шинээр батлуулах газар зүйн нэрийн үр дүнд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг ГЗБГЗЗЕГ-ын даргын А/236 дугаар тушаалаар 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулж хяналт шалгалтын ажлыг эхлүүлсэн.		
70	1117. Геодези, зураг зүйн систем хөгжүүлэх	2025 - 2028			-	Геодези, зураг зүйн дэд системүүдийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулан, батлуулахаар Гадаад харилцааны яаманд 2025 оны 03 дугаар сарын	50%	

					07-ны өдрийн н/20 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/76 дугаартай тушаалаар байгуулав. Геодези, зураг зүйн удирдлагын цахим системийг: -Улсын хилийн тэмдгийн цахим дэд систем, -1:25000-1:50000-ны масштабтай байр зүйн зургийн цахим дэд систем, -Газар зүйн нэрийн мэдээллийн цахим дэд систем зэрэг 3-н дэд системтэйгээр шинээр байгуулахаар ажлын даалгаварыг боловсруулж, холбогдох нэгжийн дарга нараас санал авч Газрын даргаар 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр АД/2025-52 дугаартай батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендерийн баримт бичгийг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Газрын даргаар батлуулав. Орон зайн систем хөгжүүлэлтийн чиглэлээр ажилладаг 4 компани руу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн н/51 дугаартай албан бичгийг хүргүүлж, 4 компаниас 2025 оны 2025 оны 06 дугаар сарын 04-ний мэдээллээ ирүүлсэн. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэх саналыг “Некст Жи Ай Эс” ХХК-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр н/60 дугаар албан бичиг хүргүүлэв. Үнийн саналыг 2025 оны 06 дугаар сарын		
--	--	--	--	--	--	--	--

						12-ны өдөр хүлээн авч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.		
71	1118. Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн модуль хөгжүүлэх	2025 - 2028	Улсын төсөв	70 сая төгрөг	60	Газрын мониторингийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийг хийлгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны АД/2025-30 дугаартайгаар батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог А/59 дугаар тушаалаар байгуулсан. Холбогдох хууль эрх зүйн хүрээнд гүйцэтгэгчийг шалгаруулж шаардлага хангасан “Софт мастер” ХХК-тай 2025.05.06-ны өдрийн 2025/74 дугаар гэрээг байгуулсан. 2025.05.09, 2025.05.12-ны өдөр ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар болон уул уурхай, ашигт малтмалын болон газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлгүй нэгж талбарын хянан баталгааг цахимжуулах ажлыг хурдан шуурхай гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгчтэй тохирсон. 2025.05.23, 2025.05.30-ны өдөр гүйцэтгэгчтэй уулзалт хийж, газрын кадастрын цахим системд бүртгэлгүй газруудад хянан баталгааны ажлыг цахимжуулах дэд цэсийн хөгжүүлэлт, бэлчээр цэсэд хийгдсэн ажлуудтай танилцаж, цаашид хийгдэх зайнаас тандан судлал, өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын зураг ашиглан мониторинг хийх, бохирдол, доройтолд орсон байршлуудыг тодорхойлох хөгжүүлэлтийн	50%	

						ажлуудад нэмэлт заавар, чиглэл өгсөн.		
72	1119. Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх	2025 - 2027	Улсын төсөв	375 сая	10	Тус ажлын хүрээнд Геопорталын 5 дэд санд "Орон зайн өгөгдлийн мэдээллийн санд чанарын шалгалт хийж, баяжуулалт, атрибут мэдээг бүрдүүлэх ажил"-ыг 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгуулан гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан "Смарт дата" ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 2025/98 дугаартай гэрээг байгуулан ажлыг эхлүүлээд байна. Явцын тайланг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авна.	70%	-
81	1164. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2025 - 2026			-	Газрын даргын 2025 оны А/42 дугаар тушаалаар "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын даалгавар" боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгаврын төслийг боловсруулан холбогдох хуралуудад танилцуулан дэмжигдсэн бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Газрын даргын АД/2025-43 дугаартайгаар батлуулсан. Тус газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ний А/135 дугаар тушаалаар Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах Зөвлөх үйлчилгээг зарлах, зохион байгуулах үүрэг	50%	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр ГЗБГЗЗЕГ/20250103006/01/01 дугаартайгаартай, 2025 оны 05 дугаар сарын 14 - нд ГЗБГЗЗЕГ/20250103006/02/01 дугаартайгаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д тус тус хоёр удаа байршуулан зарласан боловч, тендерийг нээхэд оролцогч материал ирүүлээгүй тул тендэр шалгаруулалт амжилтгүй болж

						бүхий Үнэлгээний хороог байгуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр ГЗБГЗЗЕГ/20250103006/01/01 дугаартайгаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д зарласан. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тендерийг нээхэд 1 ч оролцогч материал ирүүлээгүй байсан тул үнэлгээний хорооны шийдвэрээр тендерийг дахин 2025 оны 05 дугаар сарын 14 -нд ГЗБГЗЗЕГ/20250103006/02/01 дугаартайгаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зарласан.		2025 онд хэрэгжүүлэх боломжгүй болсон.
82	1165. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлж аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2025 он			Төлөвлөгөөний баримт бичигтэй аймгийн тоо-19	Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна.	30%	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлыг ажлын даалгаварт тусгагдсан хугацааны дагуу гүйцэтгэж байгаа болно.
83	1167. Улсын хэмжээнд хот, суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 тогтолцоонд хийх	2025 - 2028			4	2024 онд Улаанбаатар хотын 6 дүүргийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурван тэс сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэсэн. 2025 онд Дорноговь аймгийн Сайншанд, Сайхандулаан сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг хийх төсөв	50%	21 аймгийн засаг дарга нарт 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн албан бичгээр 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх төсвийг орон нутгийн төсөвт тусган ажиллах санал хүргүүлсэн. Улсын төсөв батлагдаагүйгээс 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг

						батлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.		шинэчлэх ажлыг гүйцэтгэх боломжгүй хүлээгдэж байна.
86	1187. Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, зохицуулалтын орчныг сайжруулан, цахим хэлбэрт шилжүүлэх	2025 - 2028			-	Монгол Улсын Газрын тухай хуульд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг батлахаар заасан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2.1-т “Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөн үе шаттай байхаар дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэнэ.”, 4.2.2.2-т “Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.” гэж тус тус заасан. Дээрх хууль, тогтоомжийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг шинэчлэн батлуулсан. Уг журмаар батлагдсанаар иргэн, хуулийн этгээдээс шаарддаг 15 гаруй төрлийн цаасан материалуудыг QR кодоор баталгаажуулж, системээс автоматаар үүсгэх, мөн төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийг иргэдээс дахин шаардахгүй байх боломжууд тус тус бүрдсэн.	90%	

87	1190. Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг Газрын биржийн цахим системээр зохион байгуулж, системийн шинэ хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлэх	2025 - 2028			80	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаартай тушаалаар Газрын биржийн цахим системийн (www.mle.mn)-ийн шинэчилсэн 3.0 хувилбарыг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах талаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 2/83 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлэн системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн тус системд ажиллах албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын даамлуудад цахим сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 98 газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулагдсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 86 нь цахим хэлбэрээр, 10 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 256 иргэн, хуулийн этгээд оролцож, 7 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна. Мөн 2024	100%	
----	--	-------------	--	--	----	--	------	--

						оны хагас жилийн байдлаар нийт 35 газрын газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Үүнээс 27 нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт эзэлж байна.		
88	1192. Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хөгжүүлэлтийг хийж, ашиглалтад оруулах	2025 - 2027	Улсын төсөв	231	30	Тус тендер шалгаруулалтын Ажлын даалгаврыг Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр АД/2025-32 дугаартай батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/81 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn цахим системд нийтэлсэн. 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр тендерийг нээж, 1 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн, шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй болох тухай мэдэгдлийг 2025.04.11-ны өдрийн 1/1242 дугаартай албан бичгээр хүргүүлэв. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардлагатай өөрчлөлтийг оруулж Газрын даргаар 2025.04.14-ны өдөр батлуулан шалгаруулалтыг дахин зарлав. 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр тендерийг нээж, 2 оролцогчийн ирүүлсэн тендерийг		Шаардлагад нийцсэн тендер ирээгүй.

						хянан үзэж үнэлэн шаардлага хангасан тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсан тухай мэдэгдлийг 2025.05.26-ны өдрийн 1/1868, 1/1869 дугаартай албан бичгээр оролцогчдод хүргүүлэв. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардлагатай өөрчлөлтийг оруулж Газрын даргаар батлуулан 2025.06.06-ны өдөр тендер шалгаруулалтыг дахин зарлав. 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр тендерийг нээнэ.		
89	1193. Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн болон Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн нөөц дата төвийг байгуулж, ашиглалтад оруулах	2025 - 2026	Улсын төсөв	5.4 тэрбум	0	Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (Information Security Management System, ISMS) - ISO/IEC 27001 стандартын дагуу дата төв нь хоёрдогч буюу нөөц дата төвтэй байх, үндсэн дата төв доголдох үед автоматаар нөөц төв рүү шилжих боломжтой байхыг шаарддаг бөгөөд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангахад нөөц дата төвийг байгуулах, мэдээллийн хадгалалт, нөөцлөлт, сэргээн ашиглалт, системийн хэт ачааллыг даах чадамж бүхий технологийн дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор 2026 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөлд санал боловсруулан хүргүүлэн ажилласан.	30%	2025 оны төсөвт тусгагдаагүй.

90	1194. Олон улсын стандартад нийцсэн Хаягийн мэдээллийн системийг шинэчлэн байгуулах, олон нийтэд нээлттэй байршилд суурилсан замчлалын системийг хөгжүүлэх	2026 - 2029	Гадаадын зээл тусламж	800 сая ам.доллар	50	БНСУ-ын Дотоод хэрэг, Аюулгүй байдлын яам, Газар, геоматик LX корпорац болон WUVUS ХХК-ын холбогдох мэргэжилтнүүд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсад ажиллах бэлтгэл ажлыг хангасан. Олон улсын жишигт нийцсэн хаягийн удирдлагын системийн хөгжүүлэлтийн ажлыг 2024 онд хийж гүйцэтгэн, нийслэлийн хэмжээнд 516,963 нэгж талбар, 318,510 барилгын орц гарц, 41,598 гудамжийг хаягийн удирдлагын системд зураглан оруулж, Чингэлтэй дүүргээс эхлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Үе шаттайгаар үлдсэн дүүргүүдийг хамруулан хэрэглээнд гаргахаар ажиллаж байна.	70%	БНСУ-ын KOICA олон улсын хамтын ажиллагааны санхүүжилтээр төсөл 2026 оноос эхэлнэ.
91	1195. Гудамж, нэгж талбар, барилга байгууламжийг батлагдсан стандарт, нормын дагуу тэмдэгжүүлэх	2025 - 2028			0	Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандартыг шинэчлэн боловсруулах, хаяг олгох үйл ажиллагааны журам боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан.	50%	
92	1199. Геодезийн маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулах техник, эдийн засгийн	2025			50	Геодезийн маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын төсвийг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.	30%	

	үндэслэл боловсруулах							
101	1279. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийн шугамыг шалгаж, зурагжуулах	2025 - 2028			-	Монгол Улс, ОХУ хоорондын улсын хил шалгах зорилгоор геодези, байр зүйн ажлын сонгон шалгаруулалт зохион байгуулах зөвшөөрөл авахаар 2025.02.26-нд ТЕГ-т албан бичиг хүргүүлж, Ажлын хэсгийг газрын даргын А/76 /нууц/ тушаалаар байгуулсан. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулан 2025.02.27, 03.07-нд хилийн Комиссын Монголын хэсгийн даргаар батлуулахаар хүргүүлсэн. 1991-1993 онд хийсэн өндрийн сүлжээний өгөгдлийг ОХУ-ын холбогдох агентлагаас гаргуулан авах хүсэлтийг ГХЯ-нд 2025.03.20- нд хүргүүлсэн. ОХУ-ын байгуулсан 5 цэгийн мэдээллийг 2025.04.01- нд, 4 цэг дээрх харилцан хяналтын хэмжилтийг 04.14-19, 05.18-23-нд гүйцэтгэж, тайланг 2025.06.09-нд Монголын хэсэгт хүргүүлсэн. GNSS багажны техникийн тодорхойлолтыг 2025.04.25-нд баталж, 5 иж бүрдэл багажийн үнийн саналыг 4 ААН-д хүргүүлсэн. “Агар-Од инженер” ХХК-тай гэрээ байгуулж, багажийг Булган, Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл аймагт хүлээлгэн өгч, мэргэжилтнүүдэд 2025.06.19-20-нд сургалт зохион байгуулсан. Хэвлэлийн тоног төхөөрөмж, плоттерын судалгаа хийж, холбогдох ААН-үүдээс санал авч, техникийн тодорхойлолтыг 2025.05.06-нд баталсан.	100%	

						Тендерийн баримт бичгийг 05.30-нд баталж, “Би Си Ти” ХХК-тай 2025.05.29-нд гэрээ байгуулсан. “Геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн зураг зохиох” багц ажлын эхлэлийн тайланг 2025.06.05-нд улсын санд хүлээлгэн өгсөн. Геодези, байр зүйн ажил гүйцэтгэх 3 ААН-ийн албан хаагчдад сургалтыг 05.30-нд зохион байгуулж, тайланг 06.09-нд хүргүүлсэн.		
102	1280. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын улсын хилийн шугамыг шалгаж, зурагжуулах	2025 - 2028			-	Монгол Улс, БНХАУ хоорондын улсын хил шалгах зорилгоор улсын хилийн дагуу хийгдэх геодези, байр зүйн ажлын өндрийн II ангийн 7077 км (шууд, урвуу) урттай, 10 шугамтай сүлжээг байгуулж, Хятадын өндрийн сүлжээтэй 796 км урттай (шууд, урвуу) 6 шугамаар өндрийн холболтын хэмжилт, Хиймэл дагуулын байнгын ажиллагаатай 10 станц байгуулах, байрлалын сүлжээ байгуулах, байр зүйн зураг зохиох, улсын хилийн багана, тэмдгийн солбицол, өндөр тодорхойлох тоо хэмжээ, төсвийн тооцоог гаргаж, танилцуулгын хамт ГХЯ-нд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн мн/62 албан бичгээр хүргүүлэв.	100%	